

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 32 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/97/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.Shinjlenmagadlahui.ezshaudit.mn Улаанбаатар хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 70373089, 99023682 Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас: 99036806 Цахим хаяг: Batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 99377479 Цахим хаяг: Battsetsegs@audit.gov.mn Аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК Утас: 99197346, 88114867 Цахим хаяг: Shinjlenmagadlahui.audit@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	17
5.2 Албан шаардлага	17
5.3 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН
32 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
С.БАЯРЧИМЭГ ТАНАА**

2025.04.05 № *112*

танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Хонгор сумын 32 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

2024 оны 3 сарын 21 нд Улсын бүртгэлийн 000299651 дугаартай гэрчилгээ авч 2024 оны 4 сарын 2 ноос эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлангийн 4.4.2 дахь хэсэгт дурдсан Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 -д

4525020154

заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Бусад асуудал

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 32 дугаар цэцэрлэг нь байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт 58 арга хэмжээний хүрээнд ажлаа төлөвлөж, хэрэгжилт нь 92.0 хувийн биелэлттэй ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ бүлэгт эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	88,224,936.64
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	40,117,657.60
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	40,117,657.60
3121	Төгрөг	-	40,117,657.60
31211	Төрийн сангийн харилцах	-	40,117,657.60
314	Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-
33	АВЛАГА	-	1,112,398.74
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1,112,398.74
35	БАРАА МАТЕРИАЛ	-	46,994,880.30
354	Хангамжийн материал	-	46,994,880.30
3541	Бичиг хэргийн материал	-	233,000.00
3542	Аж ахуйн материал	-	13,211,000.30
3546	Хүнсний материал	-	2,124,980.00
3547	Бусад хангамжийн материал	-	31,425,900.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	2,930,777,936.71
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	2,930,777,936.71
392	Биет хөрөнгө	-	2,928,373,770.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	-	2,871,210,303.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(31,902,336.72)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-	70,898,103.84
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(7,688,645.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	25,063,603.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(2,725,437.42)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	2,781,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(42,500.00)
39217	Ном	-	779,680.00
393	Биет бус хөрөнгө	-	2,404,166.67
39301	Програм хангамж	-	3,150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(745,833.33)
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	-	3,019,002,873.35
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	3,019,002,873.35
51	Засгийн газрын хувь оролцоо	-	3,019,002,873.35
512	Хуримтлагдсан үр дүн	-	3,019,002,873.35
5122	Тайлант үеийн үр дүн	-	3,019,002,873.35
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	-	3,019,002,873.35

ХТ05430@9022089

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	3,427,830,890.14
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	3,014,808,690.14
120	Нийтлэг татварын бус орлого	-	3,014,808,690.14
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	2,970,835,689.84
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	43,973,000.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	413,022,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	357,132,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	357,132,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	55,889,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	55,889,900.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	408,828,016.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	408,828,016.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	403,046,930.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	259,119,845.41
210101	Үндсэн цалин	-	164,821,164.00
210102	Нэмэгдэл	-	90,308,081.41
210104	Урамшуулал	-	3,990,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	30,184,195.68
210201	Тэтгэврийн даатгал	-	26,650,063.87
210202	Тэтгэмжийн даатгал	-	882,309.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	842,005.24
210204	Ажилгүйдлийн даатгал	-	408,786.73
210205	Эрүүл мэндийн даатгал	-	1,401,030.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	30,608,813.62
210301	Гэрэл, цахилгаан	-	4,446,453.62
210302	Түлш, халаалт	-	19,285,040.00
210303	Цэвэр, бохир ус	-	6,877,320.00
2105	Нормативт зардал	-	12,725,350.00
210502	Хоол, хүнс	-	12,725,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	19,500,000.00
210604	Урсгал засвар	-	19,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	871,772.57
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	871,772.57
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	50,036,953.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,220,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,711,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	43,104,753.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	5,781,086.38
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	5,781,086.38
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,781,086.38
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	3,019,002,873.35
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	3,019,002,873.35

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	413,022,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	413,022,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	357,132,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	357,132,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	55,889,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	55,889,900.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	370,429,542.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	370,429,542.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	364,648,456.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	260,232,244.15
210101	Үндсэн цалин	-	165,933,562.74
210102	Нэмэгдэл	-	90,308,081.41
210104	Урамшуулал	-	3,990,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	30,184,195.68
210201	Тэтгэврийн даатгал	-	26,650,063.87
210202	Тэтгэмжийн даатгал	-	882,308.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	842,005.24
210204	Ажилгүйдлийн даатгал	-	408,786.73
210205	Эрүүл мэндийн даатгал	-	1,401,031.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	30,608,813.62
210301	Гэрэл, цахилгаан	-	4,446,453.62
210302	Түлш, халаалт	-	19,285,040.00
210303	Цэвэр, бохир ус	-	6,877,320.00
2105	Нормативт зардал	-	14,850,330.00
210502	Хоол, хүнс	-	14,850,330.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	19,500,000.00
210604	Урсгал засвар	-	19,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	871,772.57
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	871,772.57
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,401,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,346,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	3,054,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	5,781,086.38
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	5,781,086.38


213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	<u>5,781,086.38</u>
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	<u>42,592,657.60</u>
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	<u>2,475,000.00</u>
	Дотоод эх үүсвэрээр	-	<u>2,475,000.00</u>
223001	Бусад хөрөнгө	-	<u>2,475,000.00</u>
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	<u>(2,475,000.00)</u>
145	Бусад эх үүсвэр	-	-
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	-
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	<u>40,117,657.60</u>
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	ХТ05430 @ 9022389	<u>40,117,657.60</u>

СТ-4А

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/


Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	3,019,002,873.35	3,019,002,873.35
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	3,019,002,873.35	3,019,002,873.35



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	413,022,200.00	367,123,456.02	(45,898,743.98)	88.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	413,022,200.00	367,123,456.02	(45,898,743.98)	88.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	413,022,200.00	367,123,456.02	(45,898,743.98)	88.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	290,152,200.00	260,232,244.15	(29,919,955.85)	89.69
210101	Үндсэн цалин	183,917,500.00	165,933,562.74	(17,983,937.26)	90.22
210102	Нэмэгдэл	101,305,800.00	90,308,081.41	(10,997,718.59)	89.14
210104	Урамшуулал	4,928,900.00	3,990,600.00	(938,300.00)	80.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,141,000.00	30,184,195.68	(3,956,804.32)	88.41
210201	Тэтгэврийн даатгал	23,216,400.00	26,650,063.87	3,433,663.87	114.79
210202	Тэтгэмжийн даатгал	2,730,800.00	882,308.64	(1,848,491.36)	32.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,365,600.00	842,005.24	(523,594.76)	61.66
210204	Ажилгүйдлийн даатгал	1,365,600.00	408,786.73	(956,813.27)	29.93
210205	Эрүүл мэндийн даатгал	5,462,600.00	1,401,031.20	(4,061,568.80)	25.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,389,900.00	30,608,813.62	(5,781,086.38)	84.11
210301	Гэрэл, цахилгаан	9,784,600.00	4,446,453.62	(5,338,146.38)	45.44
210302	Түлш, халаалт	23,000,000.00	19,285,040.00	(3,714,960.00)	83.85
210303	Цэвэр, бохир ус	3,605,300.00	6,877,320.00	3,272,020.00	190.76
2105	Нормативт зардал	20,247,500.00	14,850,330.00	(5,397,170.00)	73.34
210502	Хоол, хүнс	20,247,500.00	14,850,330.00	(5,397,170.00)	73.34
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,500,000.00	19,500,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	19,500,000.00	19,500,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	894,700.00	871,773.17	(22,926.83)	97.44
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	894,700.00	871,773.17	(22,926.83)	97.44
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,696,900.00	8,401,100.00	(3,295,800.00)	71.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,642,500.00	5,346,700.00	(3,295,800.00)	61.87
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,054,400.00	3,054,400.00	-	100.00



1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	413,022,200.00	413,022,200.00	(5,781,086.38)	98.60
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	357,132,300.00	357,132,300.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	357,132,300.00	357,132,300.00	-	100.00
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	55,889,900.00	55,889,900.00	(5,781,086.38)-	89.66
132001	Орон нутгийн төсвөөс	55,889,900.00	50,108,813.62	(5,781,086.38)-	89.66
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	40,117,657.60	40,117,657.60	-
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100.00
5	АЖИЛЛАГСДЫН ТОО	22	21	1	95.45

АТ05430@9022899

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй байна.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 32 дугаар цэцэрлэг нь дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллажээ. Үүнд:

- 2025-2026 оны хичээлийн жилээс үндэсний хэмжээнд хэрэгжих сургуулийн өмнөх болон бага боловсролын сургалтын хөтөлбөрийг судлах ажлыг хичээлийн жилийн 2-р улирлаас төлөвлөн хэрэгжүүлэх
- Багш бүр ээлжит хичээлийн төлөвлөлт болон сургалтын бүхий л үйл ажиллагаандаа с уралцагчийн унших чадварыг дэмжсэн арга зүйг тогтмол хэрэгжүүлэх, төрийн өмчийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 50-иас доошгүй хувьд STEAM сургалтын хөтөлбөрийг туршин хэрэгжүүлж, үр дүнг тооцох
- Багш нарын мэргэжлийн хөгжлийн бүлгийг сургууль, цэцэрлэгийн онцлог, багш нарын хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн шинэчлэн зохион байгуулан үйл ажиллагааг эрчимжүүлэх, үнэлгээ судалгаанд үндэслэн багшийг чадавхжуулах
- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас баталсан “БОЛОВСРОЛ-2032” хөтөлбөрийн хүрээнд сургалтын орчныг сайжруулах замаар багш, суралцагчийн хөгжилд ахиц гаргах
- Сургууль цэцэрлэг бүр хамтын оролцоо, үнэлгээ шинжилгээнд үндэслэн өөрийн онцлог, сурагчдын хэрэгцээ, хүний хөгжилдөө тулгуурлан сурах, сургах үйлийг дэмжсэн, байгууллагын эерэг уур амьсгал, соёл төлөвшүүлсэн менежментийн загвар боловсруулж хэрэгжүүлэх
- Орон нутгийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг багш, ажилтны мэргэжлийн онол, арга зүйн мэдлэг, чадамжийг сайжруулахад чиглүүлж, ахиц үр дүнг тооцох

7. Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих, тэдний онцлог хэрэгцээнд суурилан хөгжлийн дэмжлэгийг чанар үр дүнтэй үзүүлэхэд талуудын оролцоо, хамтын ажиллагааг идэвхжүүлэх
8. Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, орон нутгийн мэргэжлийн боловсролын болон их, дээд сургуулиудтай хамтран төрөлжсөн ахлах сургуулийг хөгжүүлэх загварыг боловсруулж, хэрэгжүүлэх бэлэн байдлыг хангах
9. Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд орон нутгийн оролцоо дэмжлэгт тулгуурласан төсөл хэрэгжүүлэн, хүүхдийн өсөлт, эрүүл мэндийг

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2024.03.27 өдрийн тогтоол, Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 128, 2024.12.25 Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 238-р тогтоолуудыг мөрдөж ажилласан.
- Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тогтоолоор батлагдсан дундаж цалин хөлс тодорхойлох журмыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоосныг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс
- Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмыг шинэчлэн баталсныг 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс
- Шинэчлэн найруулсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор бараа, ажил, үйлчилгээ худалдан авах босго үнийг шинэчлэн тогтоосныг 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс
- Монгол Улсын Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаалаар дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн баталснаар 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс тус тус мөрдөж ажиллахаар заасан байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймаг Хонгор сумын 32 дугаар цэцэрлэг 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 32 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн **3,019,002.9** мянган төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	40,117.6	40,117.6
Авлага	-	1,112.3	1,112.3
Бараа материал	-	46,994.8	46,994.8
Үндсэн хөрөнгө	-	2,930,777.9	2,930,777.9
Нийт хөрөнгө	-	3,019,002.8	3,019,002.8
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	-	3,019,002.8	3,019,002.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	-	3,019,002.8	3,019,002.8

Дархан-Уул аймаг Хонгор сумын 32 дугаар цэцэрлэг нь 2024 оны 03-р сарын 21-нд байгуулагдсан. Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь 40,117.6 мянган төгрөг байна. Энэ нь Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор 2025 оны 01 дүгээр сараас цалин хөлс 6 хувиар нэмэх шийдвэрээр төсөв нэмж өгснөөс шалтгаалсан байна. Бараа үйлчилгээний бусад зардлаас 3,867,8 мянган төгрөгийг хэмнэж, Засгийн газрын 2022 оныг 91 дүгээр тогтоолоор баталсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын 8.7-д "Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ" гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 32 дугаар цэцэрлэг нь 2024 оны 12 дугаар сарын 31 өдрийн байдлаар ер байхгүй, авлага 1,112.4 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 46,994,9 мянган төгрөг, бичиг хэргийн 233,0 мянган төгрөг, аж ахуйн материал 13,211,0 төгрөг, хангамжийн материалд 31,425,9 мянган төгрөг, хоол хүнсний зардал 2,125,0 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгийн дансны 2,930,777.9 мянган төгрөг байна. тайлант онд 3,047.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 96,475.3 мянган төгрөгийн хөрөнгө хандив тусламж хөрөнгө оруулалтаар хүлээн авсан байна. Дархан-Уул аймаг ИТХ-ын 2024 оны 09 дүгээр тогтоолоор 2,871.2 мянган төгрөгийн барилга байгууламжийг шилжүүлж авсан бусад эх үүсвэрээс 3,150.0 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд 372,904.5 мянган төгрөгөөр тооцон 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаар тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 413,022.2 мянган төгрөгөөр буюу улсын төсвийн зардлын санхүүжилтийг 40,117.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгон баталсан нь Засгийн газрын тогтоолоор цалин хөлс нэмэгдсэн, гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал олгосон, нөхөн хангалтын зардал батлагдсан зэргээс шалтгаалсан байна

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 хөтөлбөрийн 81834, 81835, 81827, 81816 арга хэмжээг санхүүжүүлэхээр Улсын төсвийн санхүүжилт 357,132.3 мянган төгрөг Орон нутгийн санхүүжилт 55,889.9 мянган төгрөг байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 357,132.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн санхүүжилт 55,889.9 мянган төгрөг буюу нийт 413,022.2 мянган төгрөг төвлөрсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 372,904.5 мянга төгрөг буюу 90,29 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 40,117.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Цалин хөлс болон урамшуулал	290,152.20	254,451.20	(35,701.0)	87.7
2	Ажил олгогчоос ндш шимтгэл	34,141.00	30,184.20	(3,956.80)	88.41
3	Бусадаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	894.70	871.80	(22.90)	97.44
4	Бараа үйлчилгээний бусад зардал	11,696.90	10,876.1	(820,8)	92.98
5	Тогтмол зардал	55,889.90	55,889.90	-	100.00

6	Хүүхдийн хоол	20,247.50	14,850.30	(5,397.20)	73.34
	Дүн	413,022.2	367,123.5	45,898.7	88,8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

2024 онд Боловсрол шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан орон тооны хязгаарын жишиг нормативын дагуу төлөвлөсөн 22 орон тоо, гүйцэтгэлээр 21 орон тоотой ажилласан байна.

Эрүүл мэндийн үзлэг шинжилгээ, багшийн сургалтын зардал, хүүхэд хамгаалал, нөхөн хангалтын зардал, ариутгал цэвэрлэгээний бодис худалдан авах, томилолт бага үнэтэй түргэн элэгдэх зардал, бичиг хэрэг, шуудан холбоо интернэтийн зардал төлбөр хураамжийн зардлууд багтсан ба нийт 13,023,1 мянган төгрөг зарцуулсан байна. Бусдаар гүйцэтгүүлсэн арга хэмжээ болон Бараа үйлчилгээний бусад зардалд нийт 12,591.6 мянган төгрөг батлагдсанаас 9,272,8 мянган төгрөг буюу 73,6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14,7-д “Ахмадын сан” байгуулаагүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ байхгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөрийн арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл бичих

Тайлант онд 61,783,4 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны 5 хөтөлбөр боловсруулж төлөвлөсөн. Хичээл үйлдвэрлэлийн зардалд 3,054,4 мянган төгрөг, мэдээлэл технологийн зардалд 469,9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 7,409,1 мянган төгрөг, урсгал засварт 19,500,0 төгрөгийг шууд худалдан авалтаар тус тус зарцуулсан.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Хонгор сумын 32 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал,

дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит" ХХК-ийн аудитор Б.Хоролбат гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Магсаржалам, гүйцэтгэх захирал С.Оргил нар дараагийн шатны чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 32 дугаар цэцэрлэгийн нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит" ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр дотоод хяналтын бүрэлдэхүүн хэсгийн талаар судалж хяналтыг хангалттай гэж үнэлсэн тул эрсдэл тодорхойлоогүй болно Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардал 73,038.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 1,460.8 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Хонгор сумын 32 дугаар цэцэрлэг нь тодорхой ажлуудыг зохион байгуулж, цалин, нийгмийн даатгалын шитгэлийн зардлыг 29,919,5 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардлыг 3,867,8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна. Үндсэн ажилтан манаач, үйлчлэгч өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөж, багш нар үр дүн аваагүй нь цалин, нийгмийн даатгалын хэмнэлт үүссэн зэрэг арга хэмжээ авч ажилласан байна. Мөн Засгийн газрын 2024 оны 12 сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор 2025 оны 01 дүгээр сараас цалин хөлс 6 хувиар нэмэх шийдвэрээр төсөв нэмж өгснөөс шалтгаалсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамааруулан шалгалаа.

зохих 166 мэдээллийн хуульд заасан хугацаанд бүрэн байршуулсан байгаа тул шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гарсан алдаа зөрчилтэй асуудал байхгүй.

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу "Ахмадын сан" байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 163 дугаар тогтоол, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/64 дүгээр тушаалын дагуу "docx.gov.mn" албан бичиг солилцооны дундын системийг ашиглаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Бичиг хэрэг, шуудангийн зардлыг бууруулах зорилгоор албан бичиг солилцооны дундын системийг ашиглах.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 32 дугаар цэцэрлэг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2024 онд үүсгэн байгуулагдсан болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 265,365.5 мянган төгрөгийн төсвийн хуваарь батлагдаж ирсэн. Мөн 2024 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 91,766,8 мянган төгрөг харилцах дансанд төвлөрснөөр төсвийн гүйцэтгэл 74,3 хувьтай гарсан байна. Иймд төсвийн төлөвлөлтэй холбоотой асуудлыг дараагийн шатны аудитаар шалгаж, шийдэл гаргах нь зүйтэй байна.

ААБ 5.5: АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Дархан-Уул аймгийн Хонгор сумын Салхит багийн 32 дугаар сургууль
Тайлант хугацаа: 2024 он

Хүснэгт Б. Санхүүгийн тайлангийн түвшинд болон ач холбогдолтой бигш АГАДҮТ-ыг үнэлсэн алдаа, зөрчлийг шийдвэрлэх

№	Тодорхойлсон эрсдэл	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Материаллаг эсэх	Үр өгөөж тооцох эсэх	Шалгуур үзүүлэлт		Алдаа зөрчлийн ангилал	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу	Гаргасан шийдэл	
						Стандартын заалт	Хууль тогтоомжийн заалт						
1	Санхүүгийн тайланг УСНББОУС болон Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан шаардлагууд болон Сангийн яамнаас гаргасан заавар журмын дагуу иж бүрэн бэлтгээгүй байх	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 163 дугаар тогтоол, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/64 дүгээр тушаалын дагуу "docx.gov.mn" албан бичиг солилцооны дундын системийг ашиглаагүй байна	-	Тийм	Үгүй	УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 163 дугаар тогтоолын 1-д "Төрийн байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах хүрээнд харьяа салбар, байгууллагын бичиг хэрэг, шуудангийн зардлыг 50-аас доошгүй хувиар бууруулж, албан ёсны лиценз бүхий баримт бичиг боловсруулах программ хангамж ашиглах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад зөвлөсүгэй" Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/64 дүгээр тушаалаар баталсан "Албан бичиг солилцооны дундын системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал"	Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой	Зөвлөмж өгөх				
2	Санхүүгийн тайланг УСНББОУС болон Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан шаардлагууд болон Сангийн яамнаас гаргасан заавар журмын дагуу иж бүрэн бэлтгээгүй байх	Ахмадын сан байгуулж, хөрөнгө мөнгө төвлөрүүлээгүй байна.	-	Тийм	Үгүй	УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга	Ахмад настны тухай хуулийн 14-р зүйлийн 14.7 " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах", Ахмадын сан байгуулан хэрэгжүүлэн ажиллах журмын 1.1, 1.2, 1.3 дахь заалт, 2.1.1 дэх заалтуудыг зөрчсөн зөрчил илэрсэн.	Хууль тогтоомжийн заалттай холбоотой асуудал.	Зөвлөмж				

3	Цалингийн тооцооллыг давтан шалгахад Ажилчдын цалин хөлс, хөдөлмөрийн хөлсний орлогыг нийгмийн даатгалд тайлагнахдаа 1,112,398.14 төгрөгийг илүү тооцож шилжүүлсэн тус Дархан-Уул аймгийн нийгмийн даатгалын хэлтсээс авахаар авлага үүсгэж залруулав	1,112,398.14	Шинж чанарын хувьд материаллаг	Үгүй	УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга	Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 "Ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх"НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 3.12, "Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-ын 3.1 дэх хэсэгНягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.4.1 "үнэн зөв байх" заалтуудыг тус тус зөрчжээ.	Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой	Санхүүгийн тайланд залруулах				
Дүн		1,112,398.1										

Бэлтгэсэн:
Аудитор

Б.Хоролбат
огноо:

Хянасан:

Чанарын хяналтын менежер

Я.Магсаржам
Огноо:

Шинжлэн магадлах үзэж ажил Х-ийн захирал

С.Оргил
Огноо:



Танилцаж зөвшөөрсөн

Дархан-Уул аймгийн Ковгор сумын Салхит багийн 32 дугаар сургууль

Дарга

Э.Баярчимэг

Огноо:

Нягтлан бодогч

П.Уянга

Огноо:

